19.11. Байрны мэдээлэл импортлох

Байрны мэдээллийг excel файл дээр бэлдэж татах боломжтой. Импортлох excel – файлын загвар нь системийн **Дата импорт -> Байр -> Загвар татах -> BuildingImportTemplate.xlsx** гэсэн нэртэй файл байна.



Өмнөх нөхцөл

- Сургалтын байгууллагын төлөв нь идэвхтэй байх

Зөвлөмж

- Тоо төрлийн талбарт зөвхөн тоон утга оруулна.
- Огноо төрлийн талбарт онсар-өдөр форматаар оруулна.
- Текст төрлийн талбарт тоо, үсэг, тэмдэгтээс бүрдсэн мэдээлэл оруулна.
- Ганц сонголт талбарт өгөгдсөн ангиллаас нэгийг сонгоно.
- Заавал бөглөх талбарын өгөгдлийг оруулсан байх.
- Тухайн мэдээлэл дэх код, нэрийг давхцуулахгүйгээр оруулах

Файлын баганын мэдээлэл

Баганы нэр	Төрөл	Тайлбар	Заавал бөглөх талбар эсэх
Сургалтын байгууллагын код	Текст	Сургалтын байгууллагын кодыг оруулна. Энэ нь Дээд боловсролын удирдлагын мэдээллийн системд сургалтын байгууллагыг давхцахгүй байдлаар кодолсон код юм. Систем тухайн кодоор сургалтын	Заавал

		байгууллагыг танина. Код буруу оруулсан тохиолдолд алдаа заана. Сургалтын байгууллагын кодыг **Систем > Манай байгууллага > Ерөнхий мэдээлэл таб > Үндсэн мэдээлэл хэсэг > Код** талбараас харна уу!	
Байрны төрөл	Ганц сонголт	Байрны төрлөөс тохирох төрлийг сонгоно. Төрлийг зөв сонгох шаардлагатай ба сонгосон төрлийн дагуу тайлан гарах болно.	Заавал
Байрны код	Текст	Байрны кодыг давхцахгүй байдлаар оруулна.	Заавал
Байрны нэр	Текст	Байрны нэрийг давхцахгүй байдлаар оруулна.	Заавал
Байрны тайлбар	Текст	Байрны талаар дэлгэрэнгүй тайлбар бичих боломжтой.	Нэмэлт
Ашиглаж байгаа эсэх	Ганц сонголт	Ашиглаж байгаа эсэх мэдээллийг оруулна. Ашиглаж байгаа бол "Тийм" сонголтыг хийнэ.	Заавал
Ашиглаж эхэлсэн огноо	Огноо	Анх ашиглалтанд орсон огноог оруулах ба огноо нь **он-сар-өдөр** гэсэн форматтай байна.	Заавал
Эзэмшлийн төрөл	Текст	Байрны эзэмшлийн төрлийг сонгоно. **Өөрийн эзэмшил** – Санхүүгийн тайлан балансд тусгагдсан өмчлөлийн хувьд тухайн сургалтын байгууллагын эзэмшилд байдаг бол энэ төрлийг сонгоно. **Түрээс** – Бусдын өмчлөлд байдаг, түрээстэй, түрээсгүйгээр ашиглаж байгаа байр бол энэ төрлийг сонгоно.	Заавал
Аймаг/Нийслэл	Текст	Байрны байрлах байршлыг сонгож бүртгэнэ.	Заавал
Сум/Дүүрэг	Текст		
Баг/Хороо	Текст		
Хөрөнгийн код	Текст	Хөрөнгийн кодыг оруулна.	Заавал
Мэдээллийн төрлийн код 1	Текст	Сургалтын орчны тайланд ашиглагдах нэмэлт мэдээллүүдийг төрөл тус бүрээр	Заавал

		оруулна. **Мэдээллийн төрлийн код** - Байрны талаарх нэмэлт мэдээллийн төрлийг сонгоно. **Мэдээллийн утга** - Тухайн сонгосон төрлийн мэдээллийн утгыг оруулна.	